МЭДЭЭ · 2021 оны 5-р сарын 6

ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ГАРАЛТ 33.9 ХУВИАР БУУРСАН БАЙНА



Энэ оны 4 дүгээр сард улсын хэмжээнд нийт 110629 зөрчлийн хэрэг бүртгэгдсэн бөгөөд өмнөх 3 дугаар сартай харьцуулахад 33.9 хувиар буурсан байна.

Нийт зөрчлийн хэргийн 98.8 хувийг цагдаагийн байгууллага, 0.3 хувийг мэргэжлийн хяналт, 0.1 хувийг онцгой байдал, 0.78 хувийг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд шалган шийдвэрлэжээ.

Дээрх хугацаанд зөрчил үйлдсэн 108759 хүн Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шийтгүүлсэн нь өмнөх сараас 34.5 хувиар, 168 хуулийн этгээд шийтгүүлсэн нь 29.2 хувиар тус тус буурсан байна.

Зөрчил үйлдсэн хүмүүсийн 81.5 хувь нь эрэгтэй, 18.5 хувь нь эмэгтэй байгаа бол дийлэнх нь буюу 67.2 хувь нь 26-45 насны хүмүүс байна.

Зөрчлийн хэргийн улмаас нийт 142 сая 441 мянган төгрөгийн хохирол учирч, 96.9 хувь нь нөхөн төлөгджээ.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭ

2021.04.01-2021.05.01

Цагдаа	109302	98.8%
Мэргэжлийн хяналт	335	0.3%
Онцгой байдал	124	0.1%
Бусад	868	0.78%

Нийт зөрчил	110629	⬇ 33.9%
Нийслэлд	89382	⬇ 30.3%
Орон нутагт	21247	⬇ 45.7%

www.prokuror.mn

Зөрчлийн улмаас учирсан хохирол	142441 мян.төг	⬇ 87.7%
Төлөгдсөн хохирол	138150 мян.төг	⬇ 83.6%
Шийтгүүлсэн хүн	108759	⬇ 34.5%
Хуулийн этгээд	168	⬇ 29.2%



88645 81.5%



20115 18.5%

0.18%	16-18 нас	25.5%	36-45 нас
16.3%	18-25 нас	11.8%	46-55 нас
41.7%	26-35 нас	4.2%	56-аас дээш нас

Буурсан зөрчил

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	331	62.3%
Мөрийтэй тоглох	12	58.7%
Хулгайлах	30	44.5%
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	92227	37.7%
Танхайрах	147	33.5%
Хүүхдийн эрхийг зөрчих	248	30.4%
Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	182	10.4%
Оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	752	9.2%
Хүний биед халдах	1385	6.8%

Өссөн зөрчил

Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих	379	97.4%
Өрсөлдөөний тухай хууль зөрчих	5	66.7%
Албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх	236	43.9%


Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлийн гаралт буурсан боловч улсын хэмжээнд гарч байгаа нийт зөрчлийн хэргийн дийлэнх хувийг буюу 83.4%-ийг эзэлж байна.

Өнгөрөгч дөрөвдүгээр сард улсын хэмжээнд бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор зарим төрлийн зөрчлийн хэргийн гаралт тодорхой хувиар буурсан байна. Тухайлбал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил 62.3 хувиар, Мөрийтэй тоглоом тоглох зөрчил 58.7 хувиар, Хулгайлах зөрчил 44.5 хувиар, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 37.7 хувиар, Танхайрах зөрчил 33.5 хувиар, Хүүхдийн эрхийг зөрчих зөрчил 30.4 хувиар, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих зөрчил 10.4 хувиар, Оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах зөрчил 9.2 хувиар, Хүний биед халдах зөрчил 6.8 хувиар тус тус буурчээ.

Хэдийгээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлийн гаралт буурсан боловч улсын хэмжээнд гарч байгаа нийт зөрчлийн хэргийн дийлэнх хувийг буюу 83.4 хувийг эзэлж байна.

Харин Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих зөрчил 97.4 хувиар, Өрсөлдөөний тухай хууль зөрчих зөрчил 66.7 хувиар, Албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх зөрчил 43.9 хувиар тус тус өсжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн 56.5 хувь нь Нийслэлд үйлдэгдсэнээс Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй дүүргүүдэд, 43.5 хувь нь орон нутагт үйлдэгдсэнээс Хөвсгөл, Баянхонгор, Булган аймгуудад хамгийн олон гарчээ. Энэ төрлийн зөрчлийн холбогдогч нарын 95.5 хувь нь эрэгтэй, 69.2 хувь нь 26-45 насны хүмүүс байна.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ

5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих

1.Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол ХҮНИЙГ 200.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.

2.Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг ХҮНИЙГ 200.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.

3.Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол ХҮНИЙГ 100.000 ТӨГРӨГӨӨР, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ 1.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОНО.

4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:
4.1.зодсон;
4.2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;
4.3.бусадтай харилцахыг хязгаарласан;
4.4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол АЛБАДАН СУРГАЛТАД ХАМРУУЛЖ 7-30 ХОНОГИЙН ХУГАЦААГААР БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛНА.

www.prokuror.mn

Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх

тухай хууль зөрчих зөрчлийн хэргийг нарийвчлан үзвэл гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон зөрчил хамгийн их үйлдэгджээ. Тодруулбал, дээрх зөрчлийн 62.2 хувь нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, 27.9 хувь хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, 8 хувь нь хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан, 1.9 хувь нь бусадтай харилцахыг хязгаарласан зөрчил байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2883